



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/632

Есөнбулаг

Хамтарсан хяналт, шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 дэх заалтууд, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цээл сумын Таяннуурын төмрийн хүдрийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Алтайн хүдэр" ХХК-ийн үйл ажиллагаанд холбогдох хууль журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар зэрэг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хамтарсан хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Дэлгэржаргал (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Л.Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга)
Д. Эрхэмбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)
Ш.Мөнхцэцэг (Аймгийн Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)
П. Ууганбаатар (Аймгийн цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн экологийн асуудал харицсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад)
Н.Дашдаваа (Аймгийн Татварын хэлтсийн жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга: Н.Алтанбагана (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын байцаагч)

2.Хяналт шалгалтыг холбогдох хуульд нийцүүлэн гүйцэтгэж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (А. Дэлгэржаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ